



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 5/28

Ховд

Ж.Мөнхзоригийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлийн 60.2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны 73 дугаар “Улс төрийн албан хаагчийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэх тогтоох тухай” тогтоолын 1 дэх заалтууд, Цэцэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдааны 6 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар 60 хувийн санал авсан Жавзандуламын Мөнхзоригийг 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн Цэцэг сумын Засаг даргаар томилсугай.

2. Ж.Мөнхзоригийг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох” 11 дүгээр хавсралтын дагуу 1052207 төгрөг /Нэг сая тавин хоёр мянга хоёр зуун долоон/-өөр цалинжуулж, албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийн хэмжээг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тооцон сар бүр олгохыг Цэцэг сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч /П.Дэлгэрхишиг/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax B/28 Ch
02 3294